

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



НАЛАЙХ ДҮҮРГИЙН
ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2019/1



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2015-2019 ОН	2
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	4
 ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	5
 НИЙГМИЙН ДААТГАЛ	7
 ЭРҮҮЛ МЭНД	8
 СОЁЛ УРЛАГ, БИЕИЙН ТАМИР	10
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	10
 ГЭМТ ХЭРЭГ	11
 ТӨСӨВ	13
 ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ	13
 АЖ ҮЙЛДВЭР	14
 ХАРИЛЦАА ХОЛБОО	16
 АЮУЛГҮЙ БАЙДАЛ	18



ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн I сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2019
Суурин хүн ам, жилийн эцэст	тоо	35 813	36 425	36 911	37 608	-
Шинээр төрсөн хүүхэд	тоо	69	46	52	54	66
Ажилгүйчүүд, сарын эцэст	тоо	754	795	371	147	121
Үүнээс: эмэгтэй	тоо	385	460	200	69	60
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	51	94	41	38	43
Бүртгэсэн гэмт хэрэг	тоо	38	40	32	61	34
Орон нутгийн төсвийн орлого	сая төгрөг	741.8	1 434.3	1 649.5	1 763.3	2 039.1
Орон нутгийн төсвийн зарлага	сая төгрөг	603.3	1 300.9	1 199.4	1 761.2	1 617.8

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

Хүснэгт 2. Дүүргүүдийн эдийн засаг, нийгмийн байдлын харьцуулсан үзүүлэлт

	Хэмжих Нэгж	2018 оны I сард					2019 оны I сард				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	294	Баянгол	7 288	Налайх	53	307	Баянгол	7 703	Налайх	55
			Чингэлтэй	1 774	Багануур	47		Чингэлтэй	1 763	Багануур	48
			Сүхбаатар	657	Багахангай	30		Сүхбаатар	698	Багахангай	31
Ажилгүйчүүд хөдөлмөрийн насны 10 000 хүнд ногдох	0\000 **	82	Багахангай	291	Баянзүрх	64	82	Багахангай	288	Баянзүрх	64
			Багануур	213	Баянгол	63		Багануур	215	Баянгол	62
			Чингэлтэй	120	Хан-Уул	61		Чингэлтэй	125	Хан-Уул	57
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00 *	14	Багахангай	25	Хан-Уул	9	14	Сонгинохайрхан	24	Хан-Уул	6
			Налайх	20	Чингэлтэй	-		Баянзүрх	15	Багануур	-
			Багануур	16	Баянгол	-		Сүхбаатар	15	Багахангай	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	13	Баянзүрх	17	Налайх	10	13	Баянзүрх	16	Сонгинохайрхан	8
			Сүхбаатар	17	Багануур	10		Чингэлтэй	16	Багануур	7
			Чингэлтэй	12	Багахангай	7		Баянгол	12	Багахангай	-
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	137	Сүхбаатар	120	Багануур	14	103	Чингэлтэй	115	Багануур	15
			Чингэлтэй	115	Налайх	12		Сүхбаатар	100	Налайх	13
			Баянгол	41	Багахангай	9		Хан-Уул	61	Багахангай	7
18-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	32	Сүхбаатар	51	Хан-Уул	24	28	Сүхбаатар	39	Налайх	14
			Баянзүрх	37	Багануур	18		Чингэлтэй	35	Багануур	14
			Чингэлтэй	34	Багахангай	7		Баянзүрх	30	Багахангай	7

Тайлбар: * - промилль

** - продицимль

Эх үүсвэр: “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2019 оны I сарын танилцуулга



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Дүүргийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2019 оны 1 дүгээр сард 121 болж, өмнөх оны мөн үеэс 26 хүнээр (17.7%) буурсан ба 49.6 хувь нь эмэгтэйчүүд эзлэж байна.

Бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 14.1 хувь нь 15-24 насны залуучууд, 35.5 хувь нь 25-34 насныхан, 29.8 хувь нь 35-44 насныхан, 16.5 хувь нь 45-54 насны, 3.3 хувь нь 55-59 насны, 0.8 хувь нь 60 ба түүнээс дээш насныхан, 2.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй адил байна.

Хүснэгт 3. Дүүргийн ажилгүйчүүд, насны бүлэг, хүйсээр, жил бүрийн I сард

Үзүүлэлт	2016 I		2017 I		2018 I		2019 I	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажилгүйчүүд	761	449	407	221	147	69	121	60
Насны бүлгээр:								
15-24	132	78	53	31	28	12	17	5
25-34	263	168	141	74	62	31	43	22
35-44	176	98	109	64	33	14	36	21
45-54	125	68	77	39	18	10	20	9
55-59	32	18	18	9	3	1	4	3
60 +	33	19	9	4	3	1	1	-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	14	6	14	2	2	2	3	1

Хүснэгт 4. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, жил бүрийн I сард

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо				Дүнд эзлэх хувь			
	2016 I	2017 I	2018 I	2019 I	2016 I	2017 I	2018 I	2019 I
Ажилгүйчүүд, бүгд	761	407	147	121	100.0	100.0	100.0	100.0
Үүнээс:								
Магистр, доктор	-	3	-	2	-	0.7	-	1.6
Дипломын болон бакалавр	166	60	26	22	21.8	14.7	17.7	18.2
Тусгай мэргэжлийн дунд	36	16	11	5	4.7	4.0	7.5	4.1
Техникийн болон мэргэжлийн	92	25	24	18	12.1	6.1	16.3	14.9
Бүрэн дунд	373	258	71	63	49.0	63.4	48.3	52.1
Суурь	66	30	8	8	8.7	7.4	5.4	6.6
Бага боловсрол	17	8	4	3	2.2	2.0	2.7	2.5
Боловсролгүй	11	7	3	-	1.5	1.7	2.1	-

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс



ИРГЭНИЙ БҮРТГЭЛ


2019 оны 1 дүгээр сард шинээр төрсөн 66 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн авч, нас барсан 20 хүнийг бүртгэлээс хасаж, 10 гэрлэлт, 5 хосын гэр бүл цуцлалтыг тус тус бүртгэсэн байна.

Шинээр мэндэлсэн хүүхдийн тоог өмнөх оны мөн үеэс 12 хүүхдээр (22.2%), нас баралт өмнөх оны мөн үеэс 2 (11.1%) тус тус өссөн байна. Нийт мэндэлсэн хүүхдийн 53.0 хувь нь хүү, 47.0 хувь нь охин байна. Нас баралтын 90.0 хувь нь эрэгтэй, 10.0 хувь нь эмэгтэй хүн эзлэж байна.

Хүснэгт 5. Төрөлт, нас баралтын бүртгэл, жил бүрийн I сард

Үзүүлэлт	2016 I	2017 I	2018 I	2019 I
Төрсөн хүүхэд, бүгд	46	52	54	66
Үүнээс: Эрэгтэй	21	22	33	35
Эмэгтэй	25	30	21	31
Нас баралт, бүгд	13	17	18	20
Үүнээс: Эрэгтэй	7	10	11	18
Эмэгтэй	6	7	7	2

Зураг 1. Хүн амын ердийн цэвэр өсөлт



Хүснэгт 6. Гэрлэлтээ бүртгүүлсэн хос, насны бүлгээр, жил бүрийн I сард

Үзүүлэлт	2017 I			2018 I			2019 I		
	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй
Нийт	34	17	17	32	16	16	20	10	10
18-19	-	-	-	-	-	-	-	-	-
20-24	4	1	3	6	3	3	6	2	4
25-29	18	9	9	18	7	11	6	4	2
30-34	6	4	2	3	3	-	3	1	2
35-39	1	-	1	-	-	-	1	1	-
40-44	3	2	1	2	2	-	2	1	1
45-49	2	1	1	1	-	1	-	-	-
50 +	-	-	-	2	1	1	2	1	1

2019 оны 1 дүгээр сард гэрлэлтээ бүртгэлийн байгууллагаар баталгаажуулсан 10 хос байгааг өмнөх оны мөн үеэс 6 (37.5%) буурсан. Хосууд тайлант онд гэр бүл болон бүртгэлээ хийлгэсэн байна. Бүртгүүлсэн нийт гэр бүл болж буй иргэдийг насны бүлгээр нь ангилбал 30.0% нь 20-24 насны, 30.0% нь 25-29 насны, 15.0% нь 30-34 насны залуучууд, 5.0% нь 35-39 насны, 10.0% нь 40-44 насны, 10.0% нь 50-аас дээш насны иргэд байна.

Хүснэгт 7. Гэр бүл цуцлалт, жил бүрийн I сард

Үзүүлэлт		2016 I	2017 I	2018 I	2019 I
Гэр бүл цуцлалт, бүгд		2	6	7	5
Гэр бүл байсан хугацаагаар (жилээр)	1 хүртэлх	-	-	-	1
	1-3	-	-	-	-
	4-6	-	2	1	-
	7-9	1	2	3	-
	10-14	-	2	2	4
	15-19	-	-	-	-
	20 ба түүнээс дээш	1	-	1	-

2019 оны 1 дүгээр сард нийт 5 хос гэр бүлээ цуцлуулсан байна. Гэр бүл байсан хугацаагаар нь ангилбал, 20.0% нь 1 хүртэлх жил, 80.0% нь 10-14 жил ханилсан хосууд байна.

Дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн гэр бүл цуцлалтын үзүүлэлтийг өмнөх оны мөн үеэс 2 (28.6%) буурсан байна. Дүүрэгт 2019 оны эхний 1 сард үрчлэгдсэн 1 эрэгтэй хүүхэд байна.

Хүснэгт 8. Үрчлэлтийн үзүүлэлт, жил бүрийн I сард

Үзүүлэлт		2016 I	2017 I	2018 I	2019 I
Үрчлэгдсэн хүүхэд, бүгд		-	1	-	1
Үүнээс: насны бүлгээр					
3 хүртэл		-	1	-	1
3-6		-	-	-	-
7-9		-	-	-	-
10 ба түүнээс дээш		-	-	-	-

Эх үүсвэр: Налайх дүүргийн Улсын бүртгэл, оюуны өмчийн хэлтэс



НИЙГМИЙН ДААТГАЛ

2019 оны 1 дүгээр сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 845.1 сая төгрөгт хүрч, нийгмийн даатгалын санд төвлөрчээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 337.5 сая төгрөг (40.0%) нь аж ахуйн нэгж байгууллага, 380.8 сая төгрөг (45.0%) нь төсөвт байгууллага, 35.0 сая төгрөг (4.1%) нь эрүүл мэндийн даатгал, 10.1 сая төгрөг (1.2%) нь үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах, 81.7 сая төгрөг (9.7%) нь нөхөн шимтгэл, сайн дурын даатгуулагчдын шимтгэл төвлөрсөн байна.

Нийгмийн даатгалын сангаас 2019 оны 1 дүгээр сард 5331 даатгуулагч иргэнд 1947.4 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна.


Хүснэгт 9. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт I сард

Үзүүлэлт	2018 I		2019 I		Даатгуулагчдын тоо	
	Даатгуу- лагчдын тоо	Олгосон дүн (сая төгрөг)	Даатгуу- лагчдын тоо	Олгосон дүн (сая төгрөг)	Тоо	Өсөлт, бууралт хувь
Нийт орлого	-	612.5	-	845.1	-	-
Нийт зардал	5 279	1 747.0	5 331	1 947.4	62	1.2
Тэтгэврийн даатгалын сан	4 665	1 471.7	4 763	1 650.1	98	2.1
Өндөр насны тэтгэвэр	3 212	1 017.6	3 308	1 138.2	96	3.0
Тахир дутуугийн тэтгэвэр	736	167.6	731	192.4	-5	-0.7
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	299	65.8	290	74.7	-9	-3.0
Цэргийн тэтгэвэр	418	220.7	434	244.8	16	3.8
ҮОМШӨ-ний даатгалын сан	483	216.9	445	214.7	-38	-7.9
Тахир дутуугийн тэтгэвэр	445	206.4	415	203.7	-30	-6.7
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	29	10.2	28	10.8	-1	-3.4
Сувиллын зардал	9	0.3	2	0.2	-7	-77.8
ҮОМШӨ ХЧТА ¹	-	-	-	-	-	-
Тэтгэмжийн даатгалын сан	121	30.6	106	58.4	-15	-12.4
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	57	0.9	55	6.4	-2	-3.5
Жирэмсний амралт	45	10.7	33	34.0	-12	-26.7
Оршуулга	19	19.0	18	18.0	-1	-5.3
Ажилгүйдлийн даатгалын сан	10	27.8	17	24.2	7	70.0
Ажилгүйдлийн тэтгэмж	10	27.8	17	24.2	7	70.0
Эрүүл мэндийн даатгалын сан	-	-	-	-	-	-
Эмчилгээ үйлчилгээний зардал	-	-	-	-	-	-
Эмийн үнийн хөнгөлөлт	-	-	-	-	-	-

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс

¹ Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн чадвараа түр алдсан

Зураг 2. Даатгалын сангийн зарлага



Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 2019 оны 1 дүгээр сард 4763, олгосон тэтгэврийн хэмжээ 1650.1 сая төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэврийн 69.0 хувийг өндөр насны 11.7 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.5 хувийг тэжээгчээ алдсан, 14.8 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



ЭРҮҮЛ МЭНД

2019 оны 1 дүгээр сард амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 5 (7.1%), нас баралт 3 (13.0%) тус тус өссөн байна.

Хүснэгт 11.Төрөлт , жил бүрийн I сард

Үзүүлэлт	2016 I	2017 I	2018 I	2019 I
Амаржсан эхийн тоо, бүгд	47	51	70	75
Амьд төрсөн хүүхэд	46	52	72	75
Амьгүй төрсөн	1	-	-	-
Эхийн эндэгдэл	-	-	-	-
Нас баралт	12	24	23	26
Үүнээс: нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	1	2	-	1
Эмнэлгийн нөхцөлд гарсан нас баралт	3	1	4	1
Гэрийн нөхцөлд гарсан нас баралт	9	19	17	19
Улаанбаатар хотод бүртгэгдсэн нас баралт ²	-	4	2	6

2019 оны 1 дүгээр сард бүртгэгдсэн нийт нас баралтын 73.1 хувийг гэрийн орчин нөхцөлд гарсан нас баралт эзэлж байгаа бол 23.1 хувийг Улаанбаатар хотод хэвтэн эмчлүүлж байгаад гарсан, 3.8 хувь хувийг дүүргийн эмнэлэгт гарсан нас баралт эзэлж байна.

² Дүүргийн харьяат иргэдээс Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлж байгаад гарсан нас баралт

Хүснэгт 12. Дүүргийн хэмжээнд гарсан халдварт өвчин, жил бүрийн I сард

Үзүүлэлт	2017 I	2018 I	2019 I	10.0 мянган хүн тутам
Нийт халдварт өвчин	41	38	43	11.6
Хурц халдварт өвчин:	1	13	9	2.4
Хепатит В вирус	-	-	-	-
Хепатит С вирус	-	-	1	0.3
Менингет	-	1	-	-
Салхин цэцэг	1	11	5	1.4
Гахайн хавдар	-	-	-	-
Паротит	-	-	-	-
Бруцеллез	-	-	-	-
Ёлом	-	-	-	-
Дизентери	-	1	2	0.5
Гар, хөл, амны өвчин	-	-	-	-
Хоолны хордлого	-	-	-	-
Сальмонеллёз	-	-	1	0.3
Сүрьеэ	6	8	9	2.4
Арьс өнгөний өвчин	34	17	25	6.8
Тэмбүү	7	4	6	1.6
Үүнээс: төрөлхийн	-	-	-	-
Заг хүйтэн	6	6	3	0.8
Хамуу	-	-	-	-
Бэлгийн замын мөөгөнцөр	14	1	7	1.9
Мөөгөнцөр	2	-	-	-
Трихомониаз	5	6	9	2.4

Эх үүсвэр: Эрүүл мэндийн төв

Эрүүл мэндийн үзүүлэлтээр дүүргийн хэмжээнд хурц халдварт өвчнөөр 9 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 (30.7%) хүнээр буурч, арьс өнгөний өвчлөл 25 гарсан нь 8 (47.0%) хүнээр, сүрьеэгээр 9 хүн өвчилсөн нь 1 (12.5%) тохиолдлоор тус тус өссөн байна. Нийт халдварт өвчний гаралт 43 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 (13.2%) өссөн байна.

Хүснэгт 13. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт, жил бүрийн I сард

Үзүүлэлт	2017 I	2018 I	2019 I	Өсөлт, бууралт хувь
Урьдчилан сэргийлэх тарилга	597	496	472	-4.8
Амбулаторын үзлэг	17 481	19 108	15 970	-16.4
Ор хоног	4 979	4 979	5 538	11.2
Эмчийн тоо	68	75	78	4.0
Сувилагчийн тоо	95	98	105	7.1
Орны тоо	177	227	227	0.0

Зураг 3. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт



Амбулаторийн үзлэгийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд 3138 (16.4%) ,урьдчилан сэргийлэх тарилга 24 (4.8%) буурсан байна. Ор хоног 559 (11.2%) өссөн байна.



СОЁЛ УРЛАГ

Дүүргийн соёл, урлагийн байгууллага 2019 оны 1 дүгээр сард нийт 5 төрлийн 24 ажил, үйлчилгээг явуулж, 250.0 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

Хүснэгт 14. Соёл, урлагийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, 2019 оны I сард

Ажил үйлчилгээ	Нийт	Үүнээс:					Номын сан (уншигчид)	Музейн ³ үзэгчид
		Урлагийн тоглолт	Хурал цуглаан	Кино үзвэр	Уралдаан тэмцээн	Дугуйлан сургалт		
Бүгд	24	6	10	-	-	8	58	-

Эх үүсвэр : Соёл урлагийн ордон



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

2019 оны 1 дүгээр сард хот тохижилтын ажил үйлчилгээний нийт орлого 11.4 сая төгрөг болж, орлогын 31.6 хувийг орон сууц, 13.1 хувийг гэр хороолол, 55.3 хувийг аж ахуйн нэгжээс хуримтлуулсан орлого эзэлж, нийтдээ 5.0 мянган тонн хогийг зөөж, тээвэрлэсэн байна.

³ Орон нутаг судлах танхим

Хүснэгт 15. Хот тохижилтын үзүүлэлт, жил бүрийн I сард

Үзүүлэлт	2017 I	2018 I	2019 I	Үүнээс:		
				Орон сууцны	Гэр хороолол	ААНБ
Нийт орлого, сая төгрөг	21.6	21.1	11.4	3.6	1.5	6.3
Хог тээвэрлэлт, мянган тонн	4.0	5.6	5.0	0.7	3.4	0.9

Эх үүсвэр: Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар

Хүснэгт 16. Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, жил бүрийн I сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 I	2017 I	2018 I	2019 I
Шахсан ус	мянган м ³	119.3	110.2	110.0	87.9
Борлуулсан ус	мянган м ³	51.5	44.0	30.5	55.5
Үүнээс: Хүн амд	мянган м ³	27.7	24.6	20.4	31.7
Аж ахуйн нэгж байгууллагад	мянган м ³	23.8	19.4	10.1	23.8
Татан зайлуулсан бохир	мянган м ³	36.6	39.7	31.2	39.1
Ус борлуулалтын орлого	сая төгрөг	52.2	55.2	35.4	76.2
Сувагжуулалтын орлого	сая төгрөг	24.1	32.0	29.2	44.6
Халаалтын орлого	сая төгрөг	17.3	20.3	42.0	22.0

Эх үүсвэр: Чандмань Налайх ОНӨААТҮГазар

2019 оны 1 дүгээр сард дүүргийн хэмжээнд 55.5 мянган м³ ус борлуулснаас, 31.7 мянган м³ (57.1%) усыг хүн амд, 23.8 мянган м³ (42.9%) усыг аж ахуйн нэгж байгууллагад түгээсэн байна.

ГЭМТ ХЭРЭГ



Дүүрэгт 2019 оны 1 дүгээр сард 34 гэмт хэрэг гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27 гэмт хэргээр (44.3%) буурч, гэмт хэргийн илрүүлэлт 10.7 хувьтай байна.


Дээрх 34 гэмт хэрэгт 6 сэжигтэн яллагдагч холбогдсон бөгөөд насны ангиллаар авч үзвэл, 30-34 насны 2, 35-39 насны 2, 50-54 насны 2 хүн байна.

Хүснэгт 17. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн I сард

Үзүүлэлт		2016 I	2017 I	2018 I	2019 I
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд		40	32	61	34
Хүн амины	Санаатай	-	-	2	-
	Учрал	2	4	2	5
	Бусдыг болгоомжгүй алах	-	-	-	-
-Хүчин		-	1	1	-
Дээрэм		-	-	2	-
Танхай		1	-	-	-
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх		-	-	2	1
Хулгай	Иргэдийн өмчийн	4	10	12	7
	Малын	-	-	2	2
	Халаасны хулгай	-	-	-	-
	Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн	2	2	15	-
	Автомашины	-	-	-	-
Булаалт		-	-	-	-
Залилан		-	1	2	2
Бусдын бие махбодид гэмтэл учруулсан		23	7	17	13
Авто тээвэр		1	1	2	2
Бусад		7	6	2	2
Хэрэгсэхгүй болгож мэдээнээс хасагдсан хэрэг		-	1	-	-
Илрүүлээгүй гэмт хэргийн тоо		1	3	57	25
Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь		88.9	75	5.3	10.7
Гэмт хэрэгт холбогдогчид, бүгд		37	24	5	6
Үүнээс:	Ажилгүй	25	16	-	4
	Албан хаагч	2	1	1	-
	Сурагч	-	3	-	-
	Оюутан	-	-	1	-
	Малчин	-	-	-	-
	Тэнэмэл иргэд	-	-	-	-
	Төрийн бус байгууллагын ажилтан	-	-	-	-
	Хугацаат цэргийн алба хаагч	-	-	-	-
	ХХЭ болон хувийн хэвшилд ажиллагч	10	4	3	2
Эрүүлжүүлэгдсэн хүн		348	227	195	258

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтэс

Зураг 4. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороодоор



Гэмт хэргийн улмаас 7 хүн нас барж, 14 хүн гэмтэж бэртсэн бөгөөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нийтдээ 36.7 сая төгрөгийн хохирол учруулсны 3.4 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна.

2019 оны 1 дүгээр сард 2163 зөрчил илрүүлж, 2060 хүнийг 51.5 сая төгрөгөөр торгож, 258 (эмэгтэй 28) хүнийг эрүүлжүүлж, 24 хүний тээврийн хэрэгсэл

жолоодох эрхийг хасаж, 1 хүнийг шүүхийн шийдвэрээр баривчлуулжээ.

2019 оны 1 дүгээр сард сард гарсан гэмт хэргийн гаралт I хороонд 11 гарч хамгийн өндөр байхад VI хорооны нутаг дэвсгэрт гарсан хэрэг зөрчилгүй байна.




ТӨСӨВ

2019 оны 1 дүгээр сард дүүргийн төсөвт 205.2 сая төгрөгийн татварын орлого төвлөрч, төлөвлөгөө 54.8 сая төгрөгөөр (36.5%) давж биелэв.

Зураг 5.Орон нутгийн татварын орлого бүрдэлт

Татварын орлогын 63.9 хувийг хүн амын орлогын албан татвар, 5.6 хувийг хог хаягдлын үйлчилгээний хураамж, 0.2 хувийг бууны татвар, 3.5 хувийг улсын тэмдэгтийн хураамжийн орлого, 26.8 хувийг хүү торгуулийн орлого түс түс бүрдүүлсэн байна.



Эх үүсвэр: Татварын хэлтэс



ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ

Түүхий эдийн үнэ өмнөх оны мөн үеэс тэмээний шир 10000 төгрөгөөр (50.0%), адууны шир 10000 төгрөгөөр (43.5%), үхрийн шир 23500 төгрөгөөр (61.0%), хонины ноостой нэхий 2500 төгрөгөөр (55.5%) буурсан байна. Ямааны ноолууртай арьс 5000 төгрөгөөр (14.3%) өссөн.

байна.

Хүснэгт 18. Зарим түүхий эдийн үнэ, жил бүрийн I сард


Түүхий эдийн нэр	Хэмжих нэгж	2016 I	2017 I	2018 I	2019 I	Хувь
		төгрөг				
Тэмээний шир	ширхэг	20 000	20 000	20 000	10 000	-50.0↓
Адууны дэл	кг	-	-	-	10 000	-
Адууны сүүл	кг	-	-	-	12 000	-
Адууны шир	ширхэг	30 000	44 000	23 000	13 000	-43.5↓
Үхрийн шир (дундаж үнэ)	1.8-2.3 метр хэмжээтэй ширхэг	43 000	45 000	38 500	15 000	-61.0↓
Хонины ноостой нэхий	ширхэг	1 000	2 000	4 500	2 000	-55.5↓
Ямааны ноолууртай арьс	ширхэг	12 000	33 000	35 000	40 000	14.3↑

Хүснэгт 19. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2018 I.31					2019 I.31				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	-	1 480	1 630	2 010	-	-	1 780	1 735	2 280	-
Петровис	2 050	1 480	1 630	2 010	-	2 195	1 690	1 735	2 285	-
Магнай трейд	2 050	1 480	1 630	2 010	-	2 195	1 690	1 735	2 285	-
Сод монгол	-	-	1 630	2 010	-	2 190	-	1 735	2 280	-
Шунхлай	2 050	-	1 630	2 010	-	2 295	1 700	1 735	2 285	-
Юнигаз	-	-	-	-	1 050	-	-	-	-	1 300
Дундаж үнэ	2 050	1 480	1 630	2 010	1 050	2 219	1 715	1 735	2 283	1 300

Эх үүсвэр: Нийслэлийн статистикийн газрын 7 хоногийн үнийн судалгааны дүн

Зураг 6. Нэг литр шатахууны дундаж үнэ жил бүрийн I сард



АЖ ҮЙЛДВЭР

2019 оны 1 дүгээр сард үйлдвэрлэгдсэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан эрчим хүч 11.9 хувиар өсөж, усан хангамж 6.6 хувиар, дулаан хангамж 32.5 хувиар

буурсан байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан эрчим хүч 6.8 хувиар өсөж, дулаан хангамж 4.8%, усан хангамж 17.3% хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 20. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, жил бүрийн I сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нийт үйлдвэрлэлт					
		Биет хэмжээгээр			Үнийн дүнгээр, сая төгрөг		
		2017 I	2018 I	2019 I	2017 I	2018 I	2019 I
Эрчим хүчний үйлдвэр:							
Цахилгаан	сая.квт.цаг	9.3	10.9	12.2	1 305.0	1 445.8	1 544.7
Дулаан	мянган гкал	20.8	20.9	14.1	376.4	398.9	379.7
Усан хангамж	мянган м ³	110.2	163.1	152.3	37.5	49.1	40.6
Олборлох үйлдвэр:							
Шохой	тонн	-	-	-	-	-	-
Нүүрс	мянган тонн	0.6	0.2	-	38.0	11.4	-
Хайрга	мянган м ³	-	-	-	-	-	-
Элс	мянган м ³	-	-	-	-	-	-
Боловсруулах үйлдвэр:							
Тоосго	мянган ширхэг	-	-	-	-	-	-
Цемент	мянган тонн	-	-	-	-	-	-
Шохой	тонн	-	-	-	-	-	-
Оёдол	мянган ширхэг	0.5	0.4	7.0	20.1	6.0	56.0
Гэр ахуйн оёмол эдлэл	мянган ширхэг	-	-	-	-	-	-
Арьсан цүнх, түрийвч эдлэл	мянган ширхэг	-	-	2.6	-	-	8.8
Замаска	тонн	-	24.4	-	-	5.9	-
Барилгын шавардлагын хар замаска	тонн	-	19	-	-	5.4	-
Плитаны цавуу	тонн	-	13.5	-	-	4.4	-
Резинэн эдлэл	сая төгрөг	-	-	-	-	-	-
Хэвлэлийн будаг	мянган ширхэг	-	-	-	-	-	-
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл:							
Талх	тонн	-	-	4.92	-	-	10.3
Нарийн боов, жигнэмэг	тонн	-	-	9.6	-	-	18.6
Хэрчсэн гурил	тонн	-	-	-	-	-	-
Бүх төрлийн ногооны консерв	тонн	-	-	-	-	-	-
Эмчилгээний цай	килограмм	-	-	350	-	-	4.7
Хүүхдийн тэжээл	тонн	-	-	-	-	-	-
Гүзээний чипс	тонн	-	-	0.02	-	-	0.7
Утсан чанасан болон хагас боловсруулсан мах	тонн	-	-	85.2	-	-	622.3
Өлөн гэдэс	мянган гогцоо	-	-	10.0	-	-	180.0
Цэвэр ус	мянган литр	-	-	379.4	-	-	54.7

Эх үүсвэр: Дүүргийн аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа тогтмол явуулсан ААН-ын дүнгээр



МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа холбооны байгууллага 19.7 сая төгрөгийн орлоготой ажиллаж, үүнээс 9.6 сая төгрөг (48.7%) нь хүн амд үзүүлсэн үйлчилгээний орлого эзэлж байна.

Телефон цэгийн тоо өмнөх оны мөн үеэс 39 (6.8%) өссөн байна. Нийт суурин телефон цэгийн 340 (55.8%) нь айл өрхийн эзэмшилд байгаа бол 200 (32.8%) нь төсвийн байгууллагад, 69 (11.4%) нь бизнесийн байгууллагуудад ашиглагдаж байна.

Хүснэгт 21. Харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлт, жил бүрийн I сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 I	2017 I	2018 I	2019 I
Нийт орлого	сая төгрөг	15.9	16.9	16.5	19.7
Үүнээс: хүн амд үзүүлсэн үйлчилгээний	сая төгрөг	7.8	8.3	8.1	9.6
Телефон цэг	тоо	540	532	570	609
Үүнээс: айл өрх	тоо	313	308	322	340
Интернет үйлчилгээний цэг	тоо	2	2	2	2
Интернет үйлчилгээний суудал	тоо	20	20	20	20
Интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчид	тоо	1 950	1 720	890	474
Интернетийн байнгын хэрэглэгчид	тоо	191	290	311	119
Таксофон	тоо	-	-	-	1

Хүснэгт 23. Кабелийн телевизийн үзүүлэлт, жил бүрийн I сард

Үзүүлэлт/он	хэмжих нэгж	2016 I	2017 I	2018 I	2019 I
КТВ-ийн орлого	Мянган төгрөг	18 007.0	14 297.8	14 738.7	5 956.0
Хэрэглэгч	тоо	5821	3650	3650	3575



АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Дүүргийн Онцгой байдлын хэлтэс 2019 оны 1 дүгээр сард гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж 37 аж ахуйн нэгж, байгууллагад 72 зөрчил илрүүлэн, 32 зөрчлийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 13, мэдэгдэл 11, зөрчлийн тэмдэглэл 6, дүгнэлт 3, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 13 хүргүүлсэн байна. Мөн объектын гал түймрийн 7 дуудлагаар ажиллаж, 54.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

Хүснэгт 22. Гал түймрийн дуудлагын тоо, жил бүрийн I сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 I	2017 I	2018 I	2019 I
Бүгд		9	10	10	7
Өмчийн хэлбэрээр:					
Төрийн өмч	тоо	-	-	2	2
Хувийн өмч	тоо	8	6	8	3
Аж ахуйн нэгж	тоо	1	4	-	2
Хамтын болон гадаад улсын өмч	тоо	-	-	-	-
Гал түймэрт өртөж шатсан:					
Нас барсан	хүүхэд	-	-	1	-
	том хүн	-	-	-	-
Түлэгдэж бэртсэн	хүүхэд	-	1	-	-
	том хүн	-	-	-	-
Өвөл зуны сууц	тоо	1	2	5	1
Гэр	тоо	2	-	2	-
Нийтийн орон сууц	тоо	-	-	-	-
Хог, хогийн сүваг	тоо	3	3	2	1
Машин техник	тоо	2	2	-	1
Барилга байгууламж	тоо	-	2	-	1
Малын хашаа саравч	тоо	1	-	-	-
Шалтгаан:					
Цахилгааны	тоо	2	1	-	-
Ил задгай асгасан үнс, нурмаас	тоо	1	-	-	-
Лаа, тамхи, шүдэнз	тоо	-	-	2	2
Пийшин зуухны цонолт	тоо	1	1	-	-
Машин техник гэмтэл, буруу ашигласан	тоо	1	1	-	-
Машин, техникийн яндангийн оч болон цахилгааны очноос	тоо	-	-	-	-
Архидан согтуурснаас	тоо	-	1	-	-
Газрын тосны бүтээгдэхүүний ашиглалтын буруугаас	тоо	-	1	-	-
Технологийн горим зөрчсөнөөс	Тоо	-	-	-	-
Бусад	Тоо	-	-	-	-
Шалтгаан тогтоогдоогүй	Тоо	4	5	8	5
Аварсан эд хөрөнгө:					
Хүн	тоо	-	-	-	-
Өвөл зуны сууц	тоо	1	2	2	1
Гэр	тоо	1	1	1	-
Барилга байгууламж	тоо	-	1	-	1
Машин техник	тоо	1	-	-	-
Нийтийн орон сууц	тоо	-	-	-	-
Улсын онц чухал болон галын онц аюултай объект	тоо	-	-	-	-
Малын хашаа саравч	тоо	-	-	-	-
Эд хөрөнгө	сая төгрөг	194.0	837.0	16.0	54.0

Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтэс

Хүснэгт 23. Газартай холбоотой асуудал шийдвэрлэлт, жил бүрийн I сард

Зориулалт	Газрын хэмжээг өөрчлөх	Газар эзэмших эрхийг хүчингүй болгох	Газар эзэмших эрх олгох	Газар эзэмших эрхийг шилжүүлэх	Газар өмчлөх	Хамтран өмчлөгч хасуулах	Газрын байршил өөрчлөх	Газар ашиглуулах эрх олгох
Иргэн, ААНБ-ын тоо	1	-	-	79	-	-	-	-

Эх үүсвэр: Өмч, газрын харилцааны алба

2019 оны 1 дүгээр сард дүүргийн Засаг даргын 3 захирамжаар нийт 80 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газартай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн байна.



ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх, хариу өгөх, хяналт тавих, тайлагнах ажлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-аар явуулж байгаагийн зэрэгцээ “Налайх сонсож байна” 7023-2727, 1800-1200 тусгай дугаарын утас, Засгийн газрын 11-11 утас, www.ub1200.mn цахим хуудас, Check my service аппликейшн зэргээр иргэдийн гомдол, хүсэлт, саналыг хүлээн авч байна.

2019 оны эхний 1 сард дүүргийн Засаг Даргын Тамгын газарт нийт 25 санал, хүсэлт, өргөдөл хүлээн авсан байна. Эдгээрээс 23 санал, хүсэлт, өргөдөлд хариу өгч, шийдвэрлэх шатандаа явагдаж байгаа 2 санал хүсэлт байна. Санал хүсэлтийн шийдвэрлэлт 92.0 хувьтай. Ирсэн өргөдөл, гомдол, саналын 24 (96.0%) нь бичгээр, 1 (4.0%) нь утсаар ирсэн байна.

Эх үүсвэр: ЗДТГ-ын нэг цонхны үйлчилгээ

Танилцуулгыг татаж авах линк :

www.ubstat.mn

www.nad.ub.gov.mn

Налайх дүүргийн Статистикийн хэлтэс facebook page

Утас: 7023-3672

УБ хот, Налайх дүүрэг ЗДТГ-ын байр 2 давхар 210 тоот